Goloml Capital®

# Хөрөнгийн зах зээлийн тойм

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв 2022.05.23

Олон улсын хөрөнгийн зах зээл

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## Онцлох индексүүдийн өөрчлөлт

*Дэлхийн томоохон индексүүдийг бүс нутгаар нь ангилан 7 хоног, сар, жилийн ханшийн өөрчлөлтүүдийг үзүүлэв. Үүнд АНУ-ын Dow Jones, S&P 500, Nasdaq, Германы Dax, Английн FTSE 100, БНХАУ-ын CSI 300, Хонг-Конгийн Hang Seng, Японы Nikkei 225 индексүүд багтана.*

| Америкийн индекс | Одоо | 7 хоногийн өмнөх | Өөрчлөлт | Сарын өмнөх | Өөрчлөлт | Жилийн өмнөх | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Dow Jones | $31,261.90 | $32,196.66 | -2.90% | $33,811.40 | -7.54% | $34,207.84 | -8.61% |
| S&P 500 | $3,901.36 | $4,023.89 | -3.05% | $4,271.78 | -8.67% | $4,155.86 | -6.12% |
| Nasdaq | $11,354.62 | $11,805.00 | -3.82% | $12,839.29 | -11.56% | $13,470.99 | -15.71% |

| Европийн индекс | Одоо | 7 хоногийн өмнөх | Өөрчлөлт | Сарын өмнөх | Өөрчлөлт | Жилийн өмнөх | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Dax | € 13,981.91 | € 14,027.93 | -0.33% | € 14,142.09 | -1.13% | € 15,437.51 | -9.43% |
| FTSE 100 | £7,389.98 | £7,372.50 | 0.24% | £7,619.16 | -3.01% | £7,019.80 | 5.27% |

| Азийн индекс | Одоо | 7 хоногийн өмнөх | Өөрчлөлт | Сарын өмнөх | Өөрчлөлт | Жилийн өмнөх | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| CSI 300 | ¥4,077.60 | ¥3,988.60 | 2.23% | ¥4,013.25 | 1.60% | ¥5,134.15 | -20.58% |
| Hang Seng | HKD 20,717.24 | HKD 19,898.77 | 4.11% | HKD 20,638.52 | 0.38% | HKD 28,458.44 | -27.20% |
| Nikkei 225 | JPY 26,739.03 | JPY 26,427.65 | 1.18% | JPY 27,105.26 | -1.35% | JPY 28,317.83 | -5.58% |




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# *Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ*

## *АНУ-ын индексүүд жижиглэн худалдааны салбарын тайлангаас болж уналаа*

*АНУ-д нфляцийн түвшин нэмэгдэж, бодлогын хүү өссөн нь айл өрхүүдийг зарцуулалтаа танахад хүргэж улмаар жижиглэн худалдаа эрхлэгч компаниудад сөргөөр нөлөөлөн борлуулалтын орлого, цэвэр ашиг, хувьцааны ханшийг бууруулсан.*

*Тухайлбал, Target компанийн тайлан зарлагдсаны дараа хувьцааны ханш нь ойролцоогоор 25 хувиар унажээ.*

*Энэ мэтээр жижиглэн худалдаа эрхлэгч компаниудын нэгдүгээр улирлын тайлан му угарснаар өнгөрсөн 7 хоногт АНУ-ын голлох индексүүд болох S&P 500 3.05 хувиар, Nasdaq 3.82 хувиар, Dow Jones 2.9 хувиар унаад байна.*

*Хөрөнгө оруулагчид ирэх саруудад жижиглэн худалдаа эрхлэгчдийн борлуулалтын орлого инфляциас болж үргэлжлүүлж унана хэмээн дүгнэж байгаа бөгөөд хөрөнгө оруулалтаа татах сэдлийг шалтгаан болж байгаа юм.*

*Холбооны Нөөцийн Сангаас инфляцийг буурах хүртэл бодлогын хүүг өсгөнө гэж мэдэгдсэн. Хэт их бодлогын хүүний өсөлт нь эдийн засгийн хямралыг авчрах талтай учраас хөрөнгийн зах зээлийн уналт үргэлжлэхээр байна.*

*Ирэх саруудын эдийн засгийн үзүүлэлт тодорхой болсноор хөрөнгө оруулагчид хөрөнгийн зах зээл үргэлжлүүлэн унах уу эсвэл буцаад сэргэх үү гэдгийг дүгнэхэд дөхөм болох юм.*

*Зарим шинжээчид хөрөнгийн зах зээл удахгүй сэргэнэ гэж үзэж “buy the dip” буюу ёроолын цэгээс нь санхүүгийн хэрэгсэл худалдаж авах зөвлөгөөг өгч байна.*

*Гэхдээ хөрөнгийн зах зээл сэргэж алдагдлаа нөхтөл багагүй хугацаа шаардагдах ба энэ нь арай “U” хэлбэртэй сэргэлт байх магадлалтай.*

*2018.12 сард S&P500 индекс 19.8 хувиар унаж, 3 сарын дотор алдагдлаа нөхөж сэргэсэн. 2020.3 сард 33.9 хувиар унаж 3.5 сарын дотор сэргэж байсан. Эдгээр үеүдэд хөрөнгийн зах зээлийн сэргэлт “V” хэлбэртэй байсан юм.*

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ




## *Европын хөрөнгийн зах зээлийн тойм*

***Европын эдийн засгийн өсөлт удааширч, бодлогын хүү өссөнөөр хувьцаануудын ханш уналттай байна.***

***Европын STOXX 600 индекс 0.55 хувиар, Германы Xetra DAX индекс 0.33 хувиар, Францын CAC 40 индекс 1.22 хувиар, Их Британийн FTSE 100 индекс 0.24 хувиар тус тус унасан. Харин Италийн FTSE MIB индекс бага зэрэг өсжээ.***

***Европын Комисс 2022 оны дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн таамаглалыг 4-өөс 2.7 хувь болгон бууруулж, эрчим хүчний үнийн өсөлтийг харгалзан инфляцийн таамаглалыг 3.5 хувиас 6.1 хувь болгон өсгөв.***

***Европын Комисс 2030 он гэхэд ОХУ-аас эрчим хүчний хараат бус байх зорилгоор REPowerEU нэртэй 300 тэрбум еврогийн төслөлхэрэгжүүлэх болсноо мэдэгдсэн. Энэ нь ОХУ-аас авдаг эрчим хүчийг бусад чулуужсан түлшээр орлуулах, ногоон эрчим хүчийг нэмэгдүүлэх, шинэ шугам хоолой, шингэрүүлсэн байгалийн хийн бааз барих гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Төсвийн ихэнх хэсгийг цар тахлын үеэр зээлсэн хараахан ашиглаж амжаагүй байсан мөнгөөр хангана.***

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд




## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.